

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

№18/479

ШУС, НУС

2017

ЭРЭН СУРВАЛЖЛАХ СЭТГҮҮЛ ЗҮЙН ХӨГЖИЛД ГАРЧ БУЙ ШИНЭ ХАНДЛАГУУД(МОНГОЛ, ХЯТАДЫН СЭТГҮҮЛ ЗҮЙН ЖИШЭЭН ДЭЭР)

Я.Ачлал* (БНХАУ)

* МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн Нийгмийн ухааны салбарын Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн магистрант

Түлхүүр үг: эрэн сурвалжлах сэтгүүл зүй, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, шинэ хандлага

Эрэн сурвалжлах сэтгүүл зүй нь нуугдмал ноцтой баримт, мэдээллийг олох, илчлэх, олон түмний сонорт хүргэх зорилго бүхий сэтгүүл зүйн чухал нэгэн бүрэлдэхүүн хэсэг болсны хувьд Монгол, Хятад хоёр улсад ид хүчтэй хөгжихийн хамт тус тусын хөгжлийн цаг хугацаа, орон зайн нөхцөлд шинэ хандлагууд ажиглагдсаар байна.

Эрэн сурвалжлах сэтгүүл зүйн тухай ойлголт, үүсэл хөгжил

Эрэн сурвалжлага гэдэг бол урьд өмнө олон нийтийн сонорт хүрээгүй, анхаарлын гадуур үлдэж байсан нууц, далд баримт мэдээллийг эрж хайх, судлах, илрүүлэх үйл ажиллагаа мөн. АНУ-ын эрэн сурвалжлах сэтгүүлчдийн нийгэмлэгийг үндэслэгч Роберт Грин “Тодорхой хувь хүн, байгууллагын нууцлахыг хүсч буй мэдээллийн гүнд нэвтэрч, нийгмийн эрх ашгийг хөндсөн чухал асуудлыг дэлгэж тавих зорилгот нийтлэл, нэвтрүүлгийг эрэн сурвалжлах сэтгүүл зүй”¹ гэж тодорхойлжээ.

Эрэн сурвалжлах сэтгүүл зүй аливаа далд асуудлыг олон нийтэд ил болгоход чиглэдэг. Ийнхүү далдалсан мэдээлэл нь хэн нэгний эрх мэдлээ урвуулан ашигласантай холбоотой, эсвэл зүгээр л ойлгоход хэцүү, замбраагүй олон мэдээллийн дунд гээгдсэн байж болно. Эрэн сурвалжлах сэтгүүл зүй нууц болон нээлттэй эх сурвалжийн аль алиныг нь ашигладаг. Эрэн сурвалжлах сэтгүүл зүйн үндсэн шинж нь далд нуугдмал байгаа зүйлийг илрүүлэхэд оршино.²

Монголын эрэн сурвалжлах сэтгүүл зүйн хөгжилтөд гарч байгаа шинэ хандлагууд

Монголд 1980-аад оны дунд үеэс эрэн сурвалжлах сэтгүүл зүйн эх суурь тавигдаж, өнөөдөр энэ чиглэлээр ажиллах сэтгүүлч, ХМХ-ийн тоо нэмэгдэж, цаашид эрчимтэй хөгжих эрх зүй, нийгэм-эдийн засгийн таатай орчин бүрэлдэх хандлагатай байна.

Монголын эрэн сурвалжлах сэтгүүл зүйн чиглэлийн шинэ сонинууд бий болж, томоохон сонины газарт эрэн сурвалжлах алба болон эрэн сурвалжлагч сэтгүүлчдийн клуб, авлигатай тэмцэгч сэтгүүлчдийн клуб байгуулагдсан. Жишээ нь: “MNB”-Эрэн

сурвалжлах алба, “Eagle TV”-Эрэн сурвалжлах нэвтрүүлгийн алба, “Глоб Интернэйшнл” ТББ г.м.

Сэтгүүлч бэлтгэдэг их, дээд сургуулиудад эрэн сурвалжлах сэтгүүл зүйн хичээлийг тусгайлан оруулж, зарим сургуульд энэ чиглэлийн сэтгүүлчдийг бэлтгэж эхэлсэн. МХХ, МУИС болон сэтгүүлчдийн мэргэжлийн байгууллагууд сэтгүүлчдэд зориулсан богино хугацааны дамжаа, семинар, сургалт зохион байгуулсан нь эрэн сурвалжлах сэтгүүл зүйн чиглэлд хийсэн шинэ алхам болсон.

Урьд эрэн сурвалжлах ажилд ихэвчлэн сонин хэвлэлийн газрууд түлхүү анхаардаг байсан бол сүүлийн жилүүдэд радио, телевизийн редакциуд янз бүрийн цуврал нэвтрүүлэг явуулж эхэлсэн нь нэн шинэлэг хандлага юм. Жишээ нь: “MNB” -“Эх сурвалж” баримт нэвтрүүлэг, “NBC” - “Эрэл”, “TV 10”- “Үнэний эрэлд”, “Монгол HD”- “Нүүдэл шийдэл” г.м.

Эрэн сурвалжлах чиглэлийн нийтлэл, нэвтрүүлгийн сэдвийн хүрээ өргөжиж, бичлэгийн төрөл зүйлийн хувьд баяжиж, ур чадвар нь сайжирч, мэдээллийн багтаамж, хүмүүсийн сэтгэл зүйд нөлөөлөх чадвар нь мэдэгдэхүйц дээшилж байна. Мөн ч сэтгүүлчид эдийн засгийн, албан тушаалын, эрүүгийн, экологийн гэмт хэрэг, авилгал, өмч хувьчлал зэрэг хууль бус аливаа үйлдлийн мөн чанарт нэвтрэх, илчлэн шүүмжлэх, түүнд олон нийтийн анхаарлыг хандуулахад идэвх санаачлагатай ажиллаж байна.

Монголын эрэн сурвалжлах сэтгүүл зүйн хөгжилд үзүүлж буй дотоод гадаад хүчин зүйлд бодитой оршиж байна. Дотоод буюу редакцийн хараат бус байдал алдагдсан, сэтгүүлчийн өөрийн цензур, айдас болгоомжлол их байгаа нь эрэн

сурвалжлах сэтгүүл зүйд нөлөөлж буй дотоод хүчин зүйл бол хууль эрх зүйн төгс бус хязгаарлагдмал орчин, албан тушаалтны цензур, хуулийн дарамт зэрэг нь гадаад орчны нөлөөлөл болж байна.

Хятадын эрэн сурвалжлах сэтгүүл зүйн (“调查性报道”) хөгжилтөд гарч байгаа шинэ хандлагууд

1980-аад оны үеэс өрнөсөн Шинэчлэл, нээлтийн үйл явц нь Хятадын сэтгүүл зүйд цоо шинэ уур амьсгалыг авч ирсэн бөгөөд эрэн сурвалжлах сэтгүүл зүй нь энэ үеэс эхэлж хөгжиж Хятадын сэтгүүл зүйн чухал, шинэ чиглэл болсон. Хятадад нэг намын тогтолцоо, ажлын арга барил хүчтэй нөлөөлж байгаа боловч сэтгүүлчдийн идэвхтэй үйл ажиллагаа нь чухал ач холбогдолтой билээ.

Эрэн сурвалжлага нь ОНМХ-ийн чухал нэгэн мэдээллийн арга барил болон хөгжиж буйг хэд хэдэн баримтаар өгүүлье.

《财经》, (“Caijing Magazine”)

1998 оноос гарч эхэлсэн энэхүү сэтгүүл нь эдийн засаг, санхүү, нийгмийн халамжийн асуудал, засгийн газрын мэдээллийн ил тод бус байдал, ХМХ-ийн нийгмийн хариуцлага зэрэг асуудалд анхаарлаа хандуулдаг. Тус сэтгүүлийн сэтгүүлчид тухайн үед Хятадын олон муж орнуудаар эрэн сурвалжлага хийж, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагатай хамтран ажиллаж өвчний үүсэл, тархалтыг бүх дэлхийд мэдээлжээ. Энэхүү сэтгүүлийн 2003 оны Хятадад дэлгэрсэн SARS өвчний тухай нийтлэл нь Хятадын эрэн сурвалжлах сэтгүүл зүйн хөгжилтийг маш ихээр түлхэн ахиулсан юм.

《新闻调查》(“News Probe”)

1996 оноос Хятадын “CCTV-1” сувгаар цацагдаж эхэлсэн энэ нэвтрүүлэг нь долоо хоногт нэг дугаар нэвтрүүлдэг. Тус нэвтрүүлэг нь

- Эрэн сурвалжилсан агуулга нь олон нийтийн эрх ашигт нийцсэн байх
- Объект нь олон нийтээс далд нууцлаг байх
- Эрэн сурвалжилсан үйл явцад сэтгүүлч өөрөө бие дааж ажилласан байх гэсэн эрэн сурвалжлах бүтээлийн 3 шаардлагыг хангаж байна гэж үзэв.

Нэвтрүүлгийн агуулга нь байгаль экологийн асуудал, нийгмийн тэгш бус байдал, хүнсний аюулгүйн байдал зэргийг илүү анхаардаг. Энэхүү нэвтрүүлэгт тусгасан улсын стандартыг хангаж чадахгүй байгаа үйлдвэр, аж ахуй, урлаг соёлын газруудын шалгалтад танил талын харилцаагаар тэнцсэн мэт асуудал нь олон нийтийн болон хамаа бүхий байгууллагын анхаарлыг татаж, асуудлыг зайлшгүй шийдвэрлэхэд хүргэсэн байна.

Интернетийн хөгжил уламжлалт эрэн сурвалжлах сэтгүүл зүйд нөлөөлж буй нь

Хятадын интернет ашиглах хүний тоо нь нэмэгдэж, 2015 оны 6 дугаар сарын байдлаар 668 сая хүн интернет ашиглаж байна. Гар утсаар дамжуулан интернет ашиглаж байгаа хүний тоо 594 саяд хүрчээ.³Интернетийн хөгжилтийг дагалдан эрэн сурвалжлагч сэтгүүлчдийн мэдээллийн эрэлтийг өсч, олон төрлийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэл дамжуулах боломжийг бүрдүүлсэн билээ.

Сүүлийн жилүүдэд цахим ертөнцөөр эрэн сурвалжлах янз бүрийн нэвтрүүлгүүд цацагдаж эхэлсэн. Ту-

хайлбал, Хятадын “CCTV”-д ажиллаж байсан сэтгүүлч Чай Жин (柴静) 2015 оны хоёрдугаар сард интернетээр дамжуулж нэвтрүүлсэн 《穹顶之下》(Under the dome) Хятадын агаарын бохирдлын тухай нэвтрүүлэг нь олон нийтийн анхаарлыг татаж, хоёр хоногт Youku.com сайтад тавьсан бичлэгийг нь 200 сая хүн үзэж, 120 мянга гаруй зурвас сэтгэгдэлтэй болсон байна.⁴ Нэвтрүүлэг нь Хятад орон даяар хүнд ноцтой утааны талаар эрэн сурвалжлага хийж, үүний улмаас Хятадын нүүрс, газрын тосны ашиглалт хийгээд зах зээлийн байдал зэрэг сэдвийг хөндсөн юм. Хэдийгээр бичлэг нь хэдхэн өдрийн дараа устсан боловч цахим ертөнц дэх нөлөөллөөс болж хамаа бүхий байгууллагын агаарын бохирдлыг шийдвэрлэх ахицыг түргэтгэсэн билээ.

Хүлээн авагч өөрөө мэдээлэл түгээж чадах болсон нь цахим ертөнцөд гарсан том хувьсал юм. Сүүлийн жилүүдэд олон нийт интернет болон “Weibo”, “Wechat”, “BBS” гэх мэт нийгмийн сүлжээг ашиглан нийгэмд оршиж байгаа бараан явдал, нууцлаг байдлыг илчлэн, “Human-powered search” гэх ойлголтыг ч бий болгоод байна.

Дүгнэлт

Монгол, Хятад хоёр улсын эрэн сурвалжлах сэтгүүл зүйн тус тусын хөгжилт хийгээд өнөөгийн байдалд бас өдий төдий асуудлууд оршиж байна. Монголын хувьд бараг бүх томоохон хэвлэл мэдээллийн хэрэгслийн эзэд, хөрөнгө оруулагчид нь улс төрчид, эрх мэдэлтнүүд байдаг болохоор дээрээс сэтгүүлчдэд өгч байгаа дарамт бага бус байна. Хятадын хувьд хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийг нам засгаас

хянаж байгаа учир сэтгүүлчид чөлөөтэй ажиллах боломж бага байдаг. Төр засаг, эрх мэдэлтнүүдийн эрх ашгийг хөндсөн тохиолдолд ажлаас нь халах тохиолдол ч бий. Редакци болон төр засгийн зүгээс дэмжих, үнэлэх боломж бага, цензур хүчтэй байгаа. Энэ нь нэг талаас эрх зүйн орчинтой хамаатай, нөгөө талаас сэтгүүлчид багаар ажиллах, ноцтой асуудал дээр хамтран ажиллах чадвар дутмаг байгааг харуулж байна. Өөрөөр хэлбэл эрэн сурвалжлах арга, технологийг эзэмшсэн байдал дутмаг байгаа юм. Их дээд сургуулиудад эрэн сурвалжлах чиглэлийн хичээл, сургалт, оюутны сурах бичиг, гарын авлага цөөн байна. Хэвлэл мэдээллийн байгууллагууд мэдлэг мэргэжлийг дээшлүүлэх талаар дутмаг ажилладаг.

Эдгээр асуудлуудыг шийдвэрлэхэд юуны өмнө хууль эрх зүйн орчныг сайжруулан, эрх зүйн тогтолцоог бүрэн төгөлдөр болгон, хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хангах хэрэгтэй. Мөн төр засгаас сэтгүүл зүйн хөгжлийг дэмжиж сэтгүүл зүйн судлал, шүүмжлэлийн чанар чансааг сайжруулах хэрэгтэй гэж үзэж байна.

Ишлэл

- ¹ *Зулькафиль М.* Эрэн сурвалжлах сэтгүүл зүйн онол, практик. УБ. 2015.х.13
- ² *Норовсүрэн Л.* Монголын сэтгүүл зүйн түүхэн тойм (III боть). УБ. 2003.х.342
- ³ CNNIC.第38次中国互联网网络发展状况统计报告. 互联网基础资源 (一).北京. 2016.

⁴葛向阳. 2015. 中国调查性报道趋势研究. 北京. P.26

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. *Зулькафиль М.* Эрэн сурвалжлах сэтгүүл зүйн онол, практик. УБ. 2015.
2. *Зулькафиль М.* Орчин үеийн сэтгүүл зүй. УБ. 2007
3. *Зулькафиль М.* Сэтгүүл зүйн тайлбар толь. УБ.2011
4. *Болд-ЭрдэнэБ.* Интернет сэтгүүл зүй. УБ.2009
5. *НоровсүрэнЛ.* Монголын сэтгүүл зүйн түүхэн тойм (III боть). УБ. 2003.
6. 葛向阳. 中国调查性报道趋势研究. 北京:- 中国青年政治学院, 2015.
7. 相德宝. 中国调查性报道研究的现状及- 其未来研究方向. 《电视研究》. 2007. №11.

Summary

This article discussed about development of investigative journalism issues in Mongolia and China for over twenty years. Investigative reporting through the initial exploration phase, gradually matured and has been associated with social progress; large number of outstanding investigative reporting for society and people brought countless inspiration; and the new tendency of the investigative reporting in Mongolia and China were considered. In the meantime because of the political control and the development of the society, there are some problem should be found and solved in the future is also discussed.